

МОНГОЛЫН СҮМ ХИЙДИЙН ТҮҮХЭН ТОВЧООН, МЭДЭЭЛЭЛ-ЯРИЛЦЛАГА

Ярилцлага өгөгчийн нэр	Гомбосүрэн	Дугаар	L298
Оршин суугаа аймаг	Хөвсгөл аймаг	Оршин суугаа сум	Цагаан-Үүр сум
Төрсөн газар	Цагаан-Үүр сум	Төрсөн он	1927
Ажил мэргэжил	Өндөр настан		
Лам байсан эсэх, Шавилан сууж байсан сүм хийд	Цагааны хүрээ	Сүм хийдийн дугаар	ХӨАЭ 043
Одоогийн сүм хийд		Сүм хийдийн дугаар	
Ярилцлага авсан он сар өдөр	2007 оны 6-р сарын 14	Ярилцлага авсан хүн	Д .Мөнхбат



Хөвсгөл аймгийн Цагаан-Үүр сумын Цагааны хүрээ

Мөнхбат: Тэгэхээр энэ Цагааны хүрээ гэдэг энэ түүр бол Хөвсгөл аймгийн Цагаан-Үүр сумын нутгийн хамгийн хойд талд Манжийн дарлалын үед тогтоогдсон Монгол улсын хилийн харуулын хайчийн хойд талдаа, одоогийн Оросын холбооны улсын Буриадтай хиллэдэг хилийн наана ийм бүс нутагт байрлаж байсан. Магадгүй Хөвсгөл аймгийн энэ бүс нутгийн хамгийн хойд талд байх буддын шашны хурал номын газар байжээ.Тэгэхээр өнөөдөр энэ Цагааны хүрээнд сууж байсан лам нар төдийгүй , энэ хүрээнд шавилж байсан өндөр настай хүмүүс нэгэнт одоо цөөрч үгүй болж энэ бараг хамгийн сүүлчийнх нь шахуу гэж хэлж болох энэ багийн өндөр настан Гомбосүрэн гуйтай бид нар дараах ярилцлагыг хийсэн юм аа. Тэгэхээр Гомбосүрэн гуйгаас, танаас бид нар ийм асуултыг асуумаар байна. Нэгдүгээрт та богино хугацаанд ч гэсэн хүүхэд насандаа тэр Цагааны хүрээнд сууж бас одоо Цагааны хүрээний ламд хадаг өргөж шавь орж байсан ийм зурвасхан түүх байх юм, таны яриа хуучаас сонсоход. Тэгээд та тэр үед хэдэн настай байсан юм, тэр хүрээ одоо ямар ямар бурхан шүтээнтэй,

МОНГОЛЫН СҮМ ХИЙДИЙН ТҮҮХЭН ТОВЧООН, МЭДЭЭЛЭЛ-ЯРИЛЦЛАГА

сахисутай шүтээнтэй байсан юм, ямар одоо цам майдар эргэх ч гэдэг юм уу шашны зан үйлийн ямар үйл явдлууд явдаг байсан юм, ер нь ямар ямар уншлагыг голчлон үйлддэг байсан юм бол оо?

Гомбосүрэн: Тэр чинь голчлон үйлдэж байгаа үеийг би бас сайн мэдэхгүй болоод байгаа юм аа. Тэрийг бол мэдэх юм алга. Уул нь бага балчир л байсан юм, хүүхэд л байгаа байх. Ерөөсөө тэр үед ер нь хэдэн настай байгаа бол, за ямар ч байсан арав хүрээгүй байсан. За тэгээд л болох юм шив ээ.

Мөнхбат: Эдүгээ нас сүүдэр та одоо хэд хүрч байгаа билээ?

Гомбосүрэн: Би одоо наяд хүрч байна.

Мөнхбат: Тэгэхээр одоо бараг далаад жилийн тэртээх л юм байна ш дээ, тийм ээ?

Гомбосүрэн: Ээ дээ, далаад жилийн тэртээх л болж таарч байна.

Мөнхбат: 1930-аад оны одоо эхэн үе л юм даа?

Гомбосүрэн: Тийм, яг л тэр л үед юм.

Мөнхбат: Тэгэхэд одоо таныг тэгж шавь орж байхад бол одоогоор хүрээний хамба лам гэдэг юм уу, хамгийн том лам нь ямар лам байсан юм бол?

Гомбосүрэн: Хамба лам нь бол Намчин гэлэн гэдэг хүн байсан юм аа.

Мөнхбат: Гэсгүй нь?

Гомбосүрэн: Гэсгүй нь Шавш гэсгүй гэж байсан. За даа, тодорхойгоос тэр хоёрыг л мэдэж байна.

Мөнхбат: Таны багш хэн гэдэг хүн байсан юм?

Гомбосүрэн: Миний багш хэн гэдэг хүн байсан, Шавш гэдэг хүн байсан юм.

Мөнхбат: Шавш гэдэг хүн байсан?

Гомбосүрэн: Тийм.

Мөнхбат: Тэгэхээр одоо ер нь нүдэн баримжаа гэдэг юм уу, эргээд санаж байхад, хүрээнийхээ түүрийг хараад эргээд санаж байхад ер нь хэд орчим дуган байсан юм бол оо, тэнд ер нь?

Гомбосүрэн: За даа ерөөсөө нэг л диваажингийн дуган, том дуган, ерөөсөө миний мэдэхийн хоёр л дуган болов уу гэж бодож байна.

Мөнхбат: Хоёр дугантай байсан?

Гомбосүрэн: Тийм.

Мөнхбат: Тэгэхээр ерөөсөө хоёр л дуганы түүрх гэдэг үнэн л байна л даа?

Гомбосүрэн: Тийм, үнэн. Хоёр л байсан юм.

Мөнхбат: Ер нь нийлээд одоо санахад ер нь хэд орчим лам нар байсан юм бол, цөөхөн л лам нар байж дээ, хоёр л дуган...?

Гомбосүрэн: Ай даа лам харин их цөөхөн л байсан болов уу. Ер нь арав хүрэхгүй л лам байгаа болов уу гэж би бодож байгаа юм.

МОНГОЛЫН СҮМ ХИЙДИЙН ТҮҮХЭН ТОВЧООН, МЭДЭЭЛЭЛ-ЯРИЛЦЛАГА

Мөнхбат: Тэгэхээр тэр арав хүрэхгүй лам хоёр дуганд суугаад уншлага номоо явуулахаар одоо байнгын ажиллагаатай байсан юм болов уу, одоогоор бол энэ түр цагийн хуралтай байсан юм болов уу? Зун намартаа, хавартаа ч гэдэг юм уу?

Гомбосүрэн: За одоо ерөөсөө тэр лам нар чинь яг тэндээ суурьшаад, тэнд орон гэртэй. Бараг л үргэлжийн л байнгын л ажиллагаатай л байгаа болов уу гэж би бодож байна.

Мөнхбат: Тэгэхээр одоо тэр Цагааны хүрээ гэдэг хүрээ 1937, 1938 оны үед явагдсан тэр их хэлмэгдүүлэлтийн тэр цаг үе дор одоо мөхсөн байдаг юм болов уу, эхлээд одоо лам нарыг нь барьж авчихаад, дараа нь сүм хийд нь хоосорч эзгүйрээд, одоо хүрээ хийд сүм дуганых нь байшингууд нь байгаад байсан тийм одоо түүх жишээ байдаг юм?

Гомбосүрэн: Тэр ч одоо урдаар лам нарыг нь баривчлаад явчихсан байх. Тэгж байгаад дуган сүм нь ч уул нь үлдэж байсан шиг бодогдох юм. За үлдэж байсныг нь тэгээд энд тэнд л зөөж ийшээ тийшээ бут татаад л алга болгочихсон болов уу л гэж бодож байгаа юм аа.

Мөнхбат: Хожим нь одоо дуган нь бол байж байсан шиг санагдаж байна уу?

Гомбосүрэн: Тийм. Хожим нь тэр улсууд нь баригдаад явчихсан хойно нь тэр дуган байж л байсан шиг санагдаж байна.

Мөнхбат: Тэгээд энэ Цагааны хүрээнээс баригдаад баривчлагдаад явсан лам нарын хувь заяа ер нь яасан бол бүр сураггүй алга болоод тэр дээд хэмжээ авсан улсууд байдаг уу, буцаж ирээд нутаг олондоо хар болоод байж байдаг лам нар байдаг болов уу, энэ талаар сонирхвол?

Гомбосүрэн: Харин тэр болвол за зарим нь ч бүр сураг байхгүй яваад л өгвөл ерөөсөө тэгээд сураг алга болсон болов уу. Уул нь манай аав Маажав гээд нэг гавж цолтой хүн байсан юм аа. За тэгээд тэр баригдаад явсан, тэгээд тэр чинь нэрийг нь цагаатгах гээд бүр энд тэндээс гурван жил хөөцөлдөөд олдсонгүй ээ. Одоо миний л аавын нэр сүр гарсангүй. Баригдаад явсан нь үнэн юм. Харин баригдаад явахдаа тэр бөөн баригдаагүй юм. За нэг жилийн дараа бараг баригдаад явсан. Тэгээд л ерөөсөө сураг гараагүй юм. Одоо би бүр энэ юунд хэлснээ, хотод миний нэг дүү байдаг юм. Тэр хөөцөлдөөд ерөөсөө нэр сүргийг нь олсонгүй дээ. Одоо тиймэрхүү л явдалтай хүн юм, би уул нь.

Мөнхбат: Тэгэхээр Цагааны хүрээнд одоо шүтэж байсан бурхан шүтээн, за тэнд уншиж байсан, хурал номд уншиж байсан ном судрууд, одоо өвлөгдөж үлдсэн энэ Даяндээрхийн хүрээнд очсон, энэ Цагаан-Үүр сумын төв дээрх шинэ тутам байгуулагдсан Ёндонпунгцаглин хийдэд очсон тийм ном судрууд байдаг юм болов уу?

Гомбосүрэн: Харин би тэрийг ерөөсөө мэдэхгүй шүү. Уул нь бурхан шүтээн ч байсан юм, мэддэг юм. Тэгээд тэр нь одоо чухам хаагуур хаагуур алга болсныг бүү мэд. Бүр холдоод хаясан юм, олсон юм байдаг бол улсаас нэг газар яасныг нь ч мэдэхгүй. Янз бүрийн бурхан шүтээн уул нь хүрээ хийдэд байгаа л даа, байж л таараа. Тэгээд тэр ерөөсөө яасныг нь ямар сайндаа мэдэхгүй байна.

Мөнхбат: За таньд баярлалаа. Ингээд Цагааны хүрээний тухай, өөрийн сүүж байсан хүрээний тухай товчхон ч гэсэн бодитой мэдээлэл өгсөн таньд их баярлалаа. Таны өгсөн мэдээлэл монголын буддын шашны түүх соёлыг

МОНГОЛЫН СҮМ ХИЙДИЙН ТҮҮХЭН ТОВЧООН, МЭДЭЭЛЭЛ-ЯРИЛЦЛАГА

сэргээх, сүм хийдийн түүхэн судалгааг гаргах манай багийн ажилд үнэтэй хувь нэмэр оруулна гэдэгт итгэж байна. Ингээд та урт удаан наслаарай.

Гомбосүрэн: За баярлалаа.

Мөнхбат :За энд нэг зүйлийг тэмдэглэн хэлэхэд манай баг ингээд Цагаан-Үүр сумын төвөөс зүүн хойш далаад км-т орших Уйлган багийн нутагт байх энэ хүрээний туурийг яг ингээд зориод гарсан болов чиг тухайн үеийн байгаль цаг уурын онцлог байгалийн хүнд байдал зэргээс шалтгаалаад ингээд туурин дээр очиж чадаагүй юм аа.Туурин дээр очиж чадаагүй болохоор зураг авалт хийгдээгүй.Аа харин зүгээр энэ нутгийн хүмүүс, сая бид нарт ярилцлага өгсөн Гомбосүрэн гуй мөн одоо энэ бусад хүмүүсийн тусламжтайгаар судалгааг хийж, аман судалгааг хийж, Цагааны хүрээний үлдсэн хоёр туурийг гаргаж ингэж одоо холбогдох бичиг баримт түүх газрын бүртгэлийн анкетуудыг тусгасан болно.